



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/134

Сүхбаатар сум

Аймгийн Засаг даргын 2020 оны А/134 дугаар  
захирамжид нэмэлт өөрчлөлт оруулж, хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "ж", "л", 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, 39 дүгээр зүйлийн 39.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, 32.1.12, Засгийн газрын 2020 оны 166 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/249 тоот тушаалаар баталсан "Үйлчилгээний зарим байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуй, халдварын сэргийлэлт, хяналтын түр журам", Улсын Онцгой комиссын 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 22 дугаар хурагдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Дэлхий нийтэд хурдацтай тархаж байгаа /COVID-19/-ын цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор "Аймгийн Засаг даргын 2020 оны А/134 тоот захирамжийн 1 дэх заалтын "5 дугаар сарын 31-ний" өдөр хүртэлх гэснийг өөрчилж, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг "2020 оны 6 дугаар сарын 30-ны" өдрийг дуустал сунгасугай.

2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй, ерөнхий боловсролын сургуулийн заалнаас бусад спортын ордон болон сумдын спорт цогцолбор, спорт заал, фитнес, теннис, биллиард, нийтийн бүжиг, амралтын газрууд, жуулчны бааз, жолооны курс, сургалтын төвийн үйл ажиллагааг тухайн байгууллагын хүчин чадлаас давсан үйлчлүүлэгч хүлээж авахгүйгээр, нэг дор олон хүн цуглуулсан нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулахгүйгээр зохицуулж, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/249 дүгээр тушаалаар батлагдсан журмыг чанд мөрдөн ажиллахыг нийт аж ахуй нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/, Онцгой байдлын газрын дарга, хурандаа /Г.Баатао/, сумдын Засаг дарга нар, аймаг, сумын сонгуулийн хорооны дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ



C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430801559